## БНМАУ, БНБАУ-ЫН ЗУРАГТ РАДИОГИЙН ХООРОНД 1971-1972 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ АЖЛЫН ПРОТОКОЛ

БНМАУ,БНБАУ-ын зурагт радиогийн байгууллагууд нь хоер байгууллагын одоогийн дагаж мөрдөж байгаа хэлэлцээрийн үндсэн дээр зурагт радиогийн талаар хамтран ажиллах төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг оруулахаар тохиролцов. Үүнд:

### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хоер тал өөр өөрсдийн зурагт радиогийн мэдээ материал-уудыг байнга харилцан солилцож байна.Үүнд сар дутам бие биедээ улс төр,эдийн засаг,соелын холбогдолтой зурагт радиогийн мэдээг явуулж байна.

### ХОЕРДУГААР ЗҮЙЛ

Ардын хувьсгалын 50 жилийн ойд зориулан монголын зурагт радио монголын ард түмний амьдрал,хөдөлмөрийн ололтын тухай зурагт радиогийн найруулгыг Болгарын зурагт радиод явуулна.

Болгарын зурагт радио Болгарын үндэсний баяр 9-р сарын 9-ны өдөрт зориулан Болгарын ард түмний амьдрал,хөдөлмөрийн ололтын тухай зурагт радиогийн найруулгыг монголын зурагт радиод явуулна.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Эдийн засаг,шинжлэх ухаан,соёлын салбарт БНМАУ,БНБАУ хамтран ажиллаж буй тухай зурагт радиогийн нэвтрүүлэг бэлтгэхэд БНМАУ,БНБАУ-ын зурагт радио бие биедээ туслалцаа үзүүлэх болно.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Болгарын зурагт радио Болгарын Коммунист Намын 10-р их хурлын тухай материалыг бэлтгэж монголын зурагт радиод явуулна.

## ТАВДУГААР ЗҮЙЛ

БНМАУ,БНБАУ-ын зурагт радио хүүхэд,залуучуудад зориулан уран зохиол,шинжлэх ухааны танин мэдэхийн сэдэв бүхий зурагт радиогийн сурвалжлага харилцан солилцоно.

## ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Хоер тал туршлага судлаж,зурагт радиогийн сурвалжлага хийх зорилгоор солилцох хүмүүсээ БНМАУ,БНБАУ-ын хооронд соёлын талаар хамтран ажиллах төлөвлөгөөнд оруулж зохицуулна.

## ДОЛДУГААР ЗҮЙЛ

Хоер тал зурагт радиогийн хроник баримтат кино,хөгжмийн

програм хүүхэд залуучуудад зориулсан киног тогтмол солилцож байх болно.

## НАЙМДУГААР ЗҮЙЛ

БНМАУ,БНБАУ-ын зурагт радио ОИРТ-ын түл ажиллагаатай уялдсан асуудлаар нягт хамтран ажиллаж өөрсдийн ажлаа зохицуулаж байх болно.

Энэхүү протоколыг 1970 оны 11-р сарын 28-ны өдөр Софи хотноо Монгол-Болгар хэл дээр үйлдэв.

Уг хоер эх нэгэн адил хүчин төгөлдөр байх болно.

МОНГОЛЫН ЗУРАГТ РАДИОГИЙН ЗАХИРГАНААС ЭРХ ОЛГОСНООР

..............................

Г.СУМЬЯА
Монголын зурагт радиогийн
Ерөнхий захирал

БОЛГАРЫН ЗУРАГТ РАДИОГИЙН ЗАХИРГАНААС ЭРХ ОЛГОСНООР

..............................

ПИСАРЕВ
Болгарын зурагт радиогийн
Захирал

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ